

Түүх 4 : Ноагийн хөвөгч авдар

Библийн эшлэл
[Эхлэл 9:16]

Үүлэнд солонго татахыг Би хараад, Бурхан Миний болон дэлхий дээрх
махбодтой хамаг амьтны хооронд байгуулсан мөнхийн гэрээгээ
санан дурсах болно гэв.

Адам, Ева хоёроос хойш олон жил өнгөрч, хүний тоо ч өсөн олширчээ.

Гэтэл хүмүүсийн гэм нүглээс болж, газар дэлхий бузар муугаар дүүрэв. Үүнийг харсан Бурхан ихэд уурлан хилэгнэжээ.

Гэхдээ тэдний дунд нэгэн зөвт хүн амьдарч байжээ.

Түүнийг Ноа гэдэг. Ноа хөршөө хайрладаг бас Бурханд ч хайртай нэгэн байлаа. Тэр үргэлж Бурхантай хамт байдаг байлаа.

Нэгэн өдөр Бурхан Ноад “Чи хөвөгч авдар хий” гэж айлдав.

Ноа, Бурханы айлдсаны дагуу ус нэвтэрч орохооргүй том хөвөгч авдрыг хийж эхэлжээ.

Ноа Бурханы зааврын дагуу бүх амьтад хос хосоороо орж чадах том хөвөгч авдар хийжээ.

Бурханы айлдсан өдөр бүх төрлийн амьтад хөвөгч авдранд оржээ.

Хөвөгч авдарт орсон хүмүүс нь Ноа болон түүний эхнэр, гурван хүү Шем, Хам, Иафет болон гурван бэр нийлээд найман хүн л байлаа. Хөвөгч авдрын хаалга хаагдангуут тэнгэрээс бороо орж эхлэв.

Тэнгэрт нүх гарсан мэт өдөр шөнөгүй тасралтгүй бороо асгарав.

Дэлхий тэр чигээрээ усанд автсан байлаа. Бороо орж эхлээд дөч хоносны дараа зогсов.

Нэгэн өдөр Ноа тагтаагаа гаргаж нисгэв. Тэгтэл түүнд суух газар олдоогүй тул буцаж ирэв.

Долоо хоногийн дараа дахин нисгэв. Энэ удаа чидун модны шинэхэн нахиа зуусан байжээ.

Ийнхүү Ноа газрын ус татарсныг мэдэв. Үер болсноос хойш гурван зуун далан хоног өнгөрч, газар хатсаны дараа Бурхан Ноад хандан айлдав. “Ноа, чи гэр бүлийнхээ хамт хөвөгч авдраас гарч болно.” Ноа гэр бүлийнхээ хамт хөвөгч авдарнаас гарав.


Ингээд Ноа Бурханд талархлын шатаалт тахил өргөв. Бурхан тэнгэрт маш үзэсгэлэнтэй солонго татуулаад энэ солонго бол Би дахин хэзээ ч мах цустай бүхнийг устгах үер буулгахгүй гэсэн “амлалтын тэмдэг” хэмээжээ.







Бүтээлч байцгаая 2. Доорх зааврын дагуу хийгээрэй.



Хөвөгч авдрыг хайчлаарай.




Давалгаан дундуурх тэмдэглэгдсэн байгаа зураасыг хайчлаарай.



Хөвөгч авдрын хойно модон савааг наагаарай.



Давалгаан дундах хайчилсан хэсэгт хөвөгч авдрыг завсраар нь хийж хөдөлгөж үзээрэй.



Дараах библийн эшлэлийг дээр нь дагаж бичээд цээжлээрэй. (Эхлэл 9:16)

мөнхийн гэрээгээ санан дурсах болно гэв.

